



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/70

Өвт

Сумын төвийн хогийн цэгийн
талбайн хогийг цэвэрлэх, булшлах ажилд
хяналт тавих ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 9.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын төвийн хогийн цэгийн талбайн хогийг цэвэрлэх, булшлах ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Батчулуун-Засаг даргын орлогч

Гишүүд Б.Янжиндулам-Байгаль орчны хяналтын улсын байцаагч

С.Төмөр-3 дугаар багийн Засаг дарга

Л.Балжинням-5 дугаар багийн засаг дарга

Ч.Бадамсүрэн-Иргэдийн төлөөлөл

2. Сумын төвийн хогийн цэгийн талбайн хогийг цэвэрлэх, булшлах ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, тэмдэглэл хөтлөн, явцын мэдээг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Батчулуун)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

М.ЖАМЪЯНШАРАВ



D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

051010139